

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/52/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: Цахим хаяг:

Аудитор: М.Мөнхнаран

Утас: 99352464 Цахим хаяг: monxoom@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
1 Аудитын тайлан	3
1.1 Оршил.....	4
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
1.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
1.10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт байгаа хэдий ч баримт бичгийн боловсруулалт муу, жишээ нь үндсэн хөрөнгийн бүртгэлийн хэсэгт хүчингүй болсон журмын заалт, ишлэл болгосон стандартыг заалт зөрсөн, бусад хэсгийн зэрэг асуудалтай байна.....	9
1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
1.12 Шилэн дансны мэдээлэл.....	10
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
2 Менежментийн захидал	11
2.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	12
2.2 Балансын данстай холбоотой асуудал.....	13
2.3 Балансын данстай холбоотой асуудал.....	14
3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019-02-20 № 7-6/104
танай _____ -ны № _____ -т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
МАНДАХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.ЭНХМЭНД**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Мандах сумын ЕБС-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал:

Тайлант хугацааны хоол хүнсний зардалд батлагдсан 25.842.320 төгрөгийн санхүүжилтээр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.4. "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Төсвийн тухай хуулийн 24.4. "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан "Цахим тендер зохион байгуулах" журам, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 24 тогтоолоор батлагдсан журмын 9.1.1 " төсвийн жилийн эхэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан төсвийг хэрхэн зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр шинээр үүсгэхгүй байх талаар төлөвлөгөө гаргаж мөрдүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Ихэнх худалдан авалт Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Е баримт НХМ-ТМ-5-аар гүйлгээ хийгдээгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7-р заалтуудыг зөрчиж анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.


Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын төвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

1.1 Оршил

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал А.Энхмэнд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.14-наас 2019.02.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг - ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын гэрээгээр "Мөнгөн Нөөц Баялаг Аудит" ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.24-ны өдрийн 11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль нь Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гаргахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

(Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа)-р Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн төвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд

төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- УСНББОУСтандарт

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтаны орон тооны жишиг нормативийг шинэчлэн тогтоосон.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acoulous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд

(/Дунд) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын 1 хувиар сонгов.

Нийт орлого -г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төлөвлөлтийн шатанд нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонгон авсан -холбоотой юм.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны *Нийт орлого* 124,235,5 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 12,423.55 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь орлогын 1 хувиас бага эрсдэл нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	95.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	25842.30	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	25937.6	

1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

"Тайлант үеийн санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэнтэй холбогдон санхүүгийн программ шинэчлэх, дахин үнэлгээг санхүүгийн тайланд тусгахдаа зөрүүтэй илэрхийлэх зэрэг бэрхшээл гарсан болно." Түүнчлэн үнэлгээ хийх хугацаа, санхүүгийн тайлан гаргах хугацаа давхцаж байгаагаас аудитын байгууллагад зөрүүтэй тайлан ирүүлэх, аудит хийх хугацаанд нөлөөлөх зэрэг асуудал гарлаа.

1.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1.10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт байгаа хэдий ч баримт бичгийн боловсруулалт муу, жишээ нь үндсэн хөрөнгийн бүртгэлийн хэсэгт хүчингүй болсон журмын заалт, ишлэл болгосон стандартыг заалт зөрсөн, бусад хэсгийн зэрэг асуудалтай байна.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 463329.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 462263.274 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь 11 хөтөлбөрийн хувьд бүгд хэмнэгдсэнтэй холбоотой

1.12 Шилэн дансны мэдээлэл

Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар Итгэмжлэл авсан.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээндээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

2.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Илрүүлэлт

Төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийхдээ зарим ажил гүйлгээний анхан шатны баримтад худалдан авалтыг баталгаажуулсан Е баримт хавсаргаагүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13 дүгээр зүйл Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААН байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврыг /НХМ-ТМ-5/ тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

1. Бүртгэлээр тавих хяналт алдагдана.
2. Татварын орлого бүрдүүлэлт, тайлагнал дутуу илэрхийлэх боломж бүрдэнэ.

Зөвлөмж

Е баримтыг худалдан авалт хийсэн ажил гүйлгээ бүрд анхан шатны нотлох баримтаар авч баримт бүрдүүлэлтийг сайжруулах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн Нягтлан бодогч Т.Мөнхтуяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

2.2 Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Санхүүгийн байдлын тайлан дахь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн эхний үлдэгдэл нь шимтгэлийн тайлангийн эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь НББ-ийн тухай хууль 20.2.5 – 6 дугаар заалт болон Төсвийн тухай хуулийн 6.4.8 дугаар заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж

Тайлант хугацааны эцэс бүрт харилцагч байгууллагатай үлдэгдлийн тулган баталгаажуулалт хийж байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн Нягтлан бодогч Т.Мөнхтуяа

Эрсдэл

1. Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

ХЧТАТэтгэмж болон 688,990 төгрөгийг олгохдоо ХХОАТатварын 10 хувь болох 68,899 төгрөг суутган гарт олгох тэтгэмжийг дутуу олгосон байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 19.2, 29 дүгээр заалт, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 16.1.1 дэх заалт, 22, 23 дугаар заалтыг тус тус зөрчсөн байна.

Тэтгэмжийг олгохдоо мөрдөгдөж байгаа хууль эрх зүйг сайн судлах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн Нягтлан бодогч Т.Мөнхтуяа

Эрсдэл

1. Хувь хүнд тэтгэмж дутуу олгогдох

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



Ч.АРИУНАА

Ц.ЛҮНДЭГМАА

М.МӨНХНАРАН

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

4.1 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,037,565.70</u>	<u>43,911,112.90</u>
33	АВЛАГА	8,446,800.00	69,320.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	946,800.00	00.00
335	Бусад авлага	7,500,000.00	69,320.00
3351	Байгууллагаас авах авлага	7,500,000.00	69,320.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,590,765.70	43,841,792.90
351	Түүхий эд материал	46,100.00	79,000.00
35130	Эм боох материал	46,100.00	79,000.00
354	Хангамжийн материал	44,544,665.70	43,762,792.90
35410	Бичиг хэргийн материал	2,059,013.00	1,002,116.00
35420	Аж ахуйн материал	31,769,987.70	29,581,562.90
35440	Түлш, шатах тослох материал	5,310,000.00	8,184,500.00
35460	Хүнсний материал	3,959,740.00	4,994,614.00
35470	Бусад хангамжийн материал	1,445,925.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>484,195,019.78</u>	<u>1,407,605,367.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	484,195,019.78	1,407,605,367.97
392	Биет хөрөнгө	484,195,019.78	1,395,589,367.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	996,075,110.00	1,473,886,998.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-580,265,465.14	-210,763,650.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,902,906.66	115,194,092.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,495,577.95	-52,407,362.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,854,331.00	80,640,231.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,441,758.97	-29,641,288.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	160,000.00	9,322,480.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,799.97	-398,333.39
39217	Ном	9,426,274.15	9,756,200.81
393	Биет бус хөрөнгө	00.00	12,016,000.00
39301	Програм хангамж	130,000.00	130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-130,000.00	-130,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	12,016,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>537,232,585.48</u>	<u>1,451,516,480.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,989,600.00</u>	<u>30,523.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,989,600.00	30,523.00
413	Өглөг	1,989,600.00	30,523.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,989,600.00	30,523.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>535,242,985.48</u>	<u>1,451,485,957.87</u>

«Audit_name»2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51	Засгийн газрын хувь оролцоо	535,242,985.48	1,451,485,957.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	327,280,313.95	349,292,953.95
51101	Өмч: - төрийн	327,280,313.95	349,292,953.95
512	Хуримтлагдсан үр дүн	207,962,671.53	918,290,495.88
51210	Өмнөх үеийн үр дүн	207,962,671.53	208,016,535.58
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	710,273,960.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	183,902,508.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	537,232,585.48	1,451,516,480.87



4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	206,843,923.00	1,242,354,556.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	698,100.00	779,024,656.66
120	Нийтлэг татварын бус орлого	698,100.00	779,024,656.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	698,100.00	779,011,156.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	698,100.00	626,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	778,384,456.66
120009	Бусад орлого	00.00	13,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,023.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,085,800.00	463,329,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	60,023.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	60,023.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	202,168,652.84	394,236,374.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	202,168,652.84	394,236,374.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,963,752.84	379,346,666.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,015,670.00	252,288,734.00
210101	Үндсэн цалин	83,672,970.00	148,670,099.00
210102	Нэмэгдэл	33,380,100.00	54,408,036.00
210104	Урамшуулал	7,200,600.00	22,392,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,762,000.00	26,817,999.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,305,495.00	29,974,432.00
210201	Тэтгэврийн даатгал	9,726,949.00	20,038,249.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,115,707.00	2,482,099.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,394,636.00	2,051,099.00
210204	Ажилгүйдлийн даатгал	278,928.00	462,749.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,789,275.00	4,940,236.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,018,773.00	14,129,489.00
210301	Гэрэл, цахилгаан	234,273.00	1,999,439.00
210302	Түлш, халаалт	5,256,500.00	11,430,050.00
210303	Цэвэр, бохир ус	528,000.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,814,260.72	14,218,250.80
210401	Бичиг хэрэг	457,600.00	2,962,427.00
210402	Тээвэр, шатахуун	1,582,150.00	1,951,265.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,950.72	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,445,925.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	531,885.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	489,560.00	7,326,748.80
2105	Нормативт зардал	12,156,835.00	26,053,122.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,600.00	291,300.00

«Audit_name»2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	12,081,835.00	24,807,446.00
210503	Нормын хувиас, зөөлөн эдлэл	37,400.00	954,376.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	72,800.00	9,472,510.00
210602	Тавилга	00.00	1,971,200.00
210604	Урсгал засвар	72,800.00	7,501,310.00
2107	Томилолт, зочны зардал	142,000.00	968,000.00
210702	Дотоод албан томилолт	142,000.00	968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,000.00	208,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	319,000.00	208,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,118,919.12	32,033,228.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	590,000.00	823,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,528,919.12	31,209,328.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,204,900.00	14,889,708.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,204,900.00	13,823,082.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,554,200.00	10,585,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,650,700.00	3,237,282.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,066,626.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,066,626.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,675,270.16	848,118,182.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	137,844,222.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	802,256.60
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	137,041,965.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-137,844,222.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,675,270.16	710,273,960.30

441714435
EHOAC058 9025707

4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	206843923.00	463970100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	698,100.00	640,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	698,100.00	640,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	698,100.00	626,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	698,100.00	626,700.00
120009	Бусад орлого	00.00	13,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	206,145,823.00	463,329,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,085,800.00	463,329,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	60,023.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	60,023.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	176,320,243.72	362,461,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	176,320,243.72	362,461,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	167,115,343.72	347,571,292.00
2101	Цалин хөлд болон нэмэгдэл урамшил	141,015,670.00	252,288,736.00
210101	Үндсэн цалин	83,672,970.00	148,670,100.00
210102	Нэмэгдэл	33,380,100.00	54,408,036.00
210104	Урамшуулал	7,200,600.00	22,392,600.00
210105	Гэрээт ажлын хөлд	16,762,000.00	26,818,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,144,400.00	30,986,707.00
210201	Тэтгэврийн даатгал	9,565,889.00	20,742,098.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,115,701.00	2,428,810.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,394,627.00	1,929,244.00
210204	Ажилгүйдлийн даатгал	278,926.00	1,016,173.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,789,257.00	4,870,382.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,381,573.00	16,291,439.00
210301	Гэрэл, цахилгаан	673,573.00	1,999,439.00
210302	Түлш, халаалт	180,000.00	13,592,000.00
210303	Цэвэр, бохир ус	528,000.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,547,400.72	4,681,150.00
210401	Бичиг хэрэг	70,000.00	327,170.00
210402	Тээвэр, шатахуун	985,850.00	2,663,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,950.72	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	531,885.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	206,600.00	1,158,280.00

«Audit_name»2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	6,541,250.00	27,019,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,250.00	408,000.00
210502	Хоол, хүнс	6,413,500.00	25,842,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	81,500.00	769,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	12,327,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	8,070,000.00
210602	Тавилга	00.00	2,050,000.00
210604	Урсгал засвар	00.00	2,207,480.00
2107	Томилолт, зочны зардал	142,000.00	968,000.00
210702	Дотоод албан томилолт	142,000.00	968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,000.00	208,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	319,000.00	208,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,024,050.00	2,799,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,024,050.00	2,799,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,204,900.00	14,889,708.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,204,900.00	13,823,082.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,554,200.00	10,585,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,650,700.00	3,237,282.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,066,626.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,066,626.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,523,679.28	101,509,100.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	206,843,923.00	463,970,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	101,509,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	101,509,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	101,509,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	101,509,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-101,509,100.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	206,843,923.00	463,970,100.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	30,523,679.28	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,523,679.28	00.00

4417144353
E:QA0056 9025707

4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,280,313.95	236,255,287.61	-60,146,137.32	503,389,464.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	171,386.08	171,386.08
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,280,313.95	236,255,287.61	-59,974,751.24	503,560,850.32
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-171,386.08	00.00	-171,386.08
C07	Тайлант үеийн үр дүн	33,437,142.00	00.00	4,675,270.16	38,112,412.16
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,280,313.95	00.00	207,962,671.53	535,242,985.48
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,280,313.95	00.00	207,962,671.53	535,242,985.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	53,864.05	53,864.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,280,313.95	00.00	208,016,535.58	535,296,849.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	183,902,508.04	00.00	183,902,508.04
D08	Тайлант үеийн үр дүн	22,012,640.00	00.00	710,273,960.30	732,286,600.30
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	918,290,495.88	1,451,485,957.87

4417144353
EICA00969825707

4.5 АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан* төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	463,329,900.00	462,263,274.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,329,900.00	462,263,274.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	449,421,900.00	448,440,192.00
210101	Үндсэн цалин	252,921,700.00	252,275,236.00
210102	Нэмэгдэл	148,738,000.00	148,656,600.00
210104	Урамшуулал	54,973,100.00	54,408,036.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,392,600.00	22,392,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,818,000.00	26,818,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,109,800.00	30,986,707.00
210201	Тэтгэврийн даатгал	21,326,600.00	20,742,098.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,445,700.00	2,428,810.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,600.00	1,929,244.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,200.00	1,016,173.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,891,700.00	4,870,382.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,301,300.00	16,291,439.00
210301	Гэрэл, цахилгаан	1,959,300.00	1,999,439.00
210302	Түлш, халаалт	13,642,000.00	13,592,000.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,003,200.00	4,806,150.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	327,170.00
210402	Тээвэр, шатахуун	2,665,700.00	2,663,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	406,000.00	125,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	610,000.00	531,885.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	976,500.00	1,158,280.00
2105	Нормативт зардал	27,020,400.00	27,019,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	408,000.00	408,000.00
210502	Хоол, хүнс	25,842,400.00	25,842,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,000.00	769,300.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	113,088,600.00	113,084,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,500,000.00	25,500,000.00

«Audit_name»2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210602	Тавилга	19,900,000.00	19,900,000.00
210604	Урсгал засвар	67,688,600.00	67,684,880.00
2107	Томилолт, зочны зардал	968,000.00	968,000.00
210702	Дотоод албан томилолт	968,000.00	968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,900.00	208,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,900.00	208,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2800000.00	2799260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,799,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13908000.00	13823082.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,908,000.00	13,823,082.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,606,200.00	10,585,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,301,800.00	3,237,282.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	463,329,900.00	463,329,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	463,329,900.00	463,329,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	463,329,900.00	463,329,900.00

441714435
EIDA005E 902570